

БНХАУ ДАХЬ ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ ОНОЛЫН СУДАЛГААНЫ БАЙДАЛ

*Н.Ариунгуа**

БНХАУ-д олон улсын харилцааны онолын судалгааг бие даасан шинжлэх ухааны төрөл, салбар гэж үздэг ба тэрхүү судалгаа нь 1980-аад оноос эхлэн бүрэлдэн бий болж эхэлжээ. Ялангуяа 90-ээд оны эхэнд олон улсын хэмжээнд Хятад улсын байр суурь, түүний гүйцэтгэх үүрэг өсөн нэмэгдэж Хятад өөрийн сонирхол, эрх ашгийн үүднээс дэлхийн тавцан дээр үйл ажиллагаа явуулж эхлэхийн сацуу олон улсын харилцааны онолын судалгаа нэлээд эрчимтэй хөгжиж ирэв.

Хятадын судлаачид гадаадын эрдэмтэдтэй хамтран олон улсын харилцааны онолын чиглэлээр тухайлбал үндэсний төр улс, олон улсын байгууллага, дайн ба энх, энх тайван ба хөгжил, олон улсын улс төр эдийн засгийн судлал /IPE/ олон улсын хамтын аюулгүйн байдлын судалгаа /ISS/, орон нутгийн засаглал, НҮБ болон дэлхийн асуудал зэрэг асуудлаар онолын судалгаа явуулж байна¹.

Хятадын олон улсын харилцааны онолын үндсийг марксизм-ленинизмын онол бүрэлдүүлэхийн зэрэгцээ барууны олон улсын харилцааны онолын судалгааны оновчтой талууд, шинжлэх ухааны арга барилыг мөн өөртөө шингээсэн гэж үзэж болно. Хятадын судлаачид америкийн олон улсын харилцааны онолчдын макро, микро түвшин дэх олон улсын харилцааны онолын бүтэц: судлагдахуун, үндсэн агуулга, судалгааны цөм, арга барилд оновчтой талууд байгааг дурдахын сацуу философийн түүхийн анализ, тууштай дүн шинжилгээ, системийн анализ, гадаад бодлогын шийдвэр гаргах явц, ангилах арга, харьцуулсан судалгаа нь логик, практик талаасаа багагүй оновчтой зүйлийг шингээсэн гэж үздэг².

БНХАУ дахь олон улсын харилцааны онолын судалгааны нэг онцлог тал бол хятад онцлогийг агуулсанд оршино. Олон улсын харилцааны судалгаан дахь хятад онцлогийн асуудлыг анх удаа хятадын онолчдоос профессор Лян Шоудэ дэвшүүлсэн байна. Гэвч хятадын зарим судлаачид олон улсын харилцааны онолд үндэсний онцлог байх ёсгүй, учир нь олон улсын харилцааны онол нь түгээмэл

*Н.Ариунгуа - ОУСХ -ийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D)

хэрэглэгдэх зүйл бөгөөд энэ утгаараа хятад онцлогтой олон улсын харилцааны онол нь шинжлэх ухааны үндэслэлгүй юм гэж үздэг юм³. Гэтэл Лян Шоудэ тэргүүтэй онолчид хятадын олон улсын харилцааны онолыг хятад онцлог бүхий байх ёстой гэж үзэж байгаа, чингэхдээ тэр нь доорхи зүйлүүдийг багтаасан байх ёстой ажээ:

1. Улсын хүчин чадал эрх ашиг гэсэн ухагдахууныг нийгмийн систем, үзэл суртлаас дээгүүр тавих

2. Тусгаар тогтнол, хүч хэрэглэх эрх хийгээд тэдгээрийн хоорондын харилцааг дөвийлгөн гаргаж өгөх

3. Үйлдвэрлэх хүчний хөгжлийн үзүүлэлтийг олон улсын улс төрийн бодлогын хүрээнд авч үзэж эдийн засгийг тэргүүлэх чиглэлд тавих үзэл баримтлалыг бүрдүүлэх, эдийн засаг улс төрийн харилцааны нөлөөллийн асуудлыг чухалчлан авч үзэх⁴.

Үүнээс гадна хятадын олон улсын харилцааны судлаачдын дунд судлагдахуун, судалгааны цар хүрээ, арга барилын талаар онолын маргаан явагдсаар байна.

I. Хятадын зарим судлаачид олон улсын харилцааны судлагдахуун нь макро, микро хоёр түвшинтэй хэмээн үздэг ба макро түвшинд олон улсын харилцааны судлагдахуун бол олон улсын бүлэглэлүүд болон их гүрнүүдийн үйл ажиллагаа гэж үздэг. Микро түвшинд орон судлал, улс хоорондын хоёр талт болон олон талт харилцаа хийгээд олон улсын харилцаан дахь тэдгээрийн нөлөөллийг судална гэж үздэг байна⁵. Гэтэл нөгөө нэг хэсэг судлаачид олон улсын харилцааны судлагдахуун бол их гүрнүүдийн улс төр, эдийн засаг, цэрэг, соёл, хууль зүйн харилцааны нэгдэл хийгээд олон улсын харилцааны ерөнхий зүй тогтол, чиглэл, хандлага зэрэг гэж үздэг⁶.

II. Олон улсын харилцааны судалгааны цар хүрээ, хамрагдах асуудлуудад:

1. Олон улсын харилцааны орчин, цаг үеийн онцлог, их гүрнүүд ба регионал шинж бүхий бүлэглэлүүдийн олон улсын хэмжээнд давамгай байдлыг олж авах үйл ажиллагааны хэлбэр загвар, онцлог, харилцан нөлөөлөл, давамгай байдал бүрэлдэн бий болох үйл явц зэрэг.

2. Олон улсын онолын судалгааны үндсэн ойлголт болох дипломат бодлого, улсын эрх ашиг, улсын эрх мэдэл, улсын хүчин чадал, олон улсын систем, олон улсын дэглэм мөн олон улсын харилцааны өөрчлөлт хөгжилд нөлөөлөх үндсэн хүчин зүйлүүд, эдийн засаг улс төрийн харилцан шүтэлцээ, тэгш бус хөгжлийн онол, олон

улсын харилцааны үндсэн хэлбэрүүд - энх тайван, хамтын ажиллагаа ба өрсөлдөөн, сөргөлдөөн үүсэх үндсэн зүй тогтлууд, дайн гарах шалтгаан, дайны шинж чанар, энх тайван хөгжлийн замыг олж авах арга, тусгаар тогтнол, энх тайвнаар зэрэгцэн орших 5 зарчим, өөртөө засан тогтнох эрх зэрэг асуудлуудыг багтааж байна⁷.

III. Судалгааны арга зүй

Олон улсын харилцааны онолын судалгааны арга зүйн талаар хятадын судлаачдын дунд хоёр чиглэл байдаг. Нэг дэх чиглэл бол марксизм-ленинизмын онолыг судалгааны арга зүйн хувьд хэрэглэх. Хоёр дахь чиглэл бол микро түвшин дэх олон улсын харилцааны онолыг нотлох арга зүйг баримтлан боловсруулах юм.

Хятадын олон улсын харилцааны онолын судалгааны талаар ярихдаа олон улсын харилцааны өрнөдийн чиглэлийн онолыг хятадын эрдэмтэд хэрхэн яаж үздэг, тэдгээрийг хэрхэн үнэлдэг вэ гэсэн асуудлыг хөндөх нь зүйтэй юм.

Хятадын эрдэмтдийн үзэж байгаагаар XX зууны 80-аад оноос өрнөдийн олон улсын харилцааны онолын хэрэгжилт нь засгийн газрын бодлого, төлөвлөлттэй маш нарийн уялдаа холбоотой болж байна гэж үзэж байна. Америкийн олон улсын харилцааны онол нь “Америкийн эрх ашгийг глобалчлах” номлол болж тэр нь Америкийн гадаад бодлогын стратегид шууд үйлчилдэг гэж үзэж байна⁸. Тухайлбал шинэ реализмын онол нь нэг талаас олон улсын интеграцлалыг чухалчилдаг боловч нөгөө талаас Америкийн гадаад бодлогын шинэ сэтгэлгээний нэг төрөл гэж үзэж байгаа юм. Нөгөөтэйгүүр барууны олон улсын харилцааны онол нь Америк төвтэй их гүрнүүдийн онол юм гэж үзэж байна. Тухайлбал геоэкологийн онол нь зөвхөн өндөр хөгжилтэй орнуудын эдийн засгийн харилцааг судалдаг, Америкийн олон улсын харилцааны онолд жижиг буурай орнууд, гуравдахь ертөнцийн орнуудын талаар огт дурьддаггүй нь системийн онол, зэрэгцэн орших онол, олон улсын улс төр, эдийн засгийн судлалд шийдэгдээгүй асуудал үүсгэж байна гэж үзэж байна. Нөгөөтэйгүүр өрнөдийн зарим эрдэмтэд умард өмнөдийн харилцааг дэвшүүлж тавьснаар гуравдахь ертөнцийн орнуудын шаардлага, байр суурийг мушгин гуйвуулж байна гэсэн дүгнэлтэнд хүрчээ.

Хятад судлаачид даяарчлал бол дэлхийн түүхэн хөгжлийн хандлага гэдгийг хүлээн зөвшөөрөхийн хамт барууны даяарчлалын тухай шинэ онолын ихэнхи нь “Америк төвтэй” буюу “баруун төвтэй” онол байдаг гээд глобалчлал гэдэг үг нь уг чанартаа дэлхий дээрхи

Америкийн тэргүүлэх үүрэг гэсэн утгыг илэрхийлж байна гэж үзэж байна. Иймээс барууны онолчид дэлхийн шинэ дэглэмийн онолын талаар маш ихээр ярьж буй өнөө үед Хятад улс ч Хятадын Засгийн газраас дэвшүүлсэн дэлхийн улс төр, эдийн засгийн шинэ дэглэмийн тухай үзэл баримтлалыг хөгжүүлэн боловсруулах шаардлагатай гэж үзэж байгаа юм.

Үүнээс гадна Хятадын онолчид олон улсын байдлын өөрчлөлтийн онолыг улсын эрх ашиг, дэлхийн аюулгүйн байдлын өнцгөөс нарийвчлан судлах, энх тайван болон хөгжлийн асуудлыг олон улсын сөргөлдөөн, хямрал, цөмийн дайн хийгээд гуравдахь ертөнц гэсэн асуудлаар судлах, олон улсын улс төр, эдийн засгийн системийг улс гүрнүүдийн зэрэгцэн орших, хамтын ажиллагаа зэрэг онолын асуудлаар боловсруулах, мөн олон улсын хүний эрхийн асуудлаар пролетари ангийн эрхийг онол, практикийн үүднээс сайн тайлбарлах хэрэгтэй гэж үзэж, дээр дурьдсан үндсэн 5 асуудлыг Хятадын олон улсын харилцааны судалгаанд эн тэргүүнд зайлшгүй судлагдах асуудлууд гэж үзэж байна.

Ийнхүү БНХАУ-д олон улсын харилцааны онолын судалгаа нэлээд эрчимтэй явагдаж энэ чиглэлээр хятад онцлог бүхий цоо шинэ онол, шинэ сэтгэлгээг бүрдүүлэхийг зорьж байна.

ИШЛЭЛ

1. Ни Шивэй Дан дай сифэн гуоцзи гуанси ли лунь. Орчин үеийн барууны олон улсын харилцааны онол. Шанхай 2001. тал 490
2. Ни Шивэй. Орчин үеийн барууны олон улсын харилцааны онол. Шанхай 2001. тал 503
3. Ван Лян. “Хятад онцлогтой олон улсын харилцааны онолыг боловсруулах тухай эрдэм шинжилгээний хуралд дүн шинжилгээ өгөх нь”. “Гуоцзи чжэнжи яньцзю” сэтгүүл, 1994, №8
4. Лян Шоудэ. Хятад дахь олон улсын улс төр судалгаа - олон улсын улс төрийн онол дахь “Хятад онцлог”-ийн талаар дахин ярихад, “Гуоцзи чжэнжи” сэтгүүл. 1997, №4
5. Шанхайд болсон олон улсын харилцааны судлалын талаархи хурлын материал. “Олон улсын харилцааны онолын анхны судалгаа”. Шанхай, 1991, тал 19
6. Мөн тэнд. тал 15
7. Лян Шишэн Гуан юй гуоцзи гуанси сюэ цзян шэ дэ цзигэ вэньги. Олон улсын харилцааны судлалын талаархи зарим асуудлууд. “Вай цзяо сюэюань сюэбао”, 1996, №8
8. Ни Шивэй. Дээр дурьдсан зохиол. Тал 502